

НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Огноо : 2019.10.11

Тендер шалгаруулалтын нэр: Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Сумын төвийг 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам /Увс, Наранбулаг сум/”

Тендер шалгаруулалтын дугаар: ЭХЯ/201912013

Эрчим хүчний яам нь эрх бүхий тендерт оролцогчдоос Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Сумын төвийг 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамд холбох” ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу. Тендерт оролцохын тулд эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар цахим тендерийн хураамж төлнө.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: 2018, 2017, 2016 оны Борлуулалтын орлогын аль нэг жилд нь санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй;

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ нь санал болгож буй үнийн 30 хувиас багагүй;

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2018, 2017, 2016 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг ирүүлнэ.

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: 2018, 2017, 2016 оны аль нэг жилд нь санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг гүйцэтгэсэн байна.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:

- 03.2.3 “Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар 0.4-35 кВ” болон түүнээс дээш /Эрчим хүчний яам/, 03.9.3 0.4-110 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах болон түүнээс дээш /Эрчим хүчний яам/

Тендерийн хамт 67,336,000 төгрөгийн үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: Эрхгүй

Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцохгүй.

Тендерийг 2019 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 10:00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 10:30 цагт нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Монгол, Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө,
Засгийн газрын XIV байр, Утас: 51263066, Факс: 70043479
Имэйл хаяг: info@energy.gov.mn
Веб сайт: www.energy.gov.mn